

Ёс суртахууны сентиментализмын хувьсал: Шафтесбюригээс

Слөүт хүртэл

Э.Баасандорж, магистр багш
МУИС, Философи, шашин судлалын тэнхим

Хураангуй: Уг өгүүлэлд Шотландын соён гэгээрлээс эхтэй ёс суртахууны сентиментализм хэрхэн хувьсаж ирснийг цогцоор нь авч үзнэ. Шафтесбюри, Хатчесон нар хүнд угаас заяасан байх ёс суртахууны мэдрэмжийн талаар ярьсан бол залгамжлагчид нь болох Хьюм, Смит нар ёс суртахууны мэдрэмжийн оронд симпати гэх зүйлийг онолынхоо төвд тавьсан бий. Энэ өгүүлээр сонгодог сентименталист санаа ХХ зуунд логик позитивистуудаар дамжин мета ёс зүйн эмотивист, өргөн хүрээндээ экспрессивист үзэл бүрэлдэхэд ихээхэн нөлөөлсөн тухайд, цаашилаад өнөө үед сентиментализм нь мета ёс зүй, норматив ёс зүйн салбарт чухал байр суурьтай хэвээр байгаа төдийгүй эмпирик сэтгэл судлал, шийдвэр гаргалтын онолын салбарт гарсан ололтуудаар баяжиж хэрхэн боловсронгуй болсныг харуулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: ёс суртахууны сентимент, симпати, эмпати, ёс суртахууны мэдрэмж, экспрессивизм

Ёс суртахууны сентиментализм нь ёс суртахууныг сэтгэл хөдлөл, мэдрэмж, хүсэл тэмүүлэл гэх мэт оюун ухаанд үл хамаарах буюу рационал бус зүйлсээс эхтэй гэх үзэл юм. Ийм эсвэл үүнтэй төстэй санааг дэвшүүлж байсан эртний философичид бий. Жишээ нь, Мэнз эртний Хятадад хүний уг чанарын талаарх асуудлыг авч үзэхдээ рэн (仁) буюу нинжин сэтгэл эсвэл хүнлэг байдал хэмээн орчуулж болох ойлголтыг нэлээд онцолж үзсэн байдаг. Күнзийн уламжлалд чухал үүрэгтэй байсан энэ ойлголт нь Мэнзийн хувьд хүмүүс нэг нэгнийхээ сайн сайханд санаа тавих чанарыг илэрхийлдэг. Түүнийхээр хүн худагт унах гэж буй хүүхдийг харвал янз бүрийн ашиг, тооцоо бодохоос урьдаар мөнөөх хүүхдэд санаа зовох учир түүнийг аврах болно (Mencius, 2003). Энэ бол хүн рационал тооцооллоос урьдаар бусдын зовлонг хуваалцах мэдрэмждээ хөтлөгдөж ямар үйлдэл хийхээ шийддэгийг харуулж болох жишээ мөн. Ийм учраас Мэнзийг ёс суртахууны сентименталист хэмээн үзэх нь нэлээд үндэслэлтэй юм. Түүнчлэн рэн-ийг сүүл үед бий болсон эмпати хэмээх ойлголттой жишиж үзэх ч боломж байдаг (Terjesen, 2013). Гэхдээ сентиментализмыг гол төлөв англи хэлтэй философи уламжлалд хамаатуулдаг бөгөөд энэхүү өгүүлэлд чухам энэ урсгалын түүхийг л онцлон авч үзэх болно.

Сентиментализмын үүслийг соён гэгээрлийн үеийн Шотландын философичид болох Энтони Күүпер буюу Шафтесбюрийн гуравдугаар гүн, Фрэнсис Хатчесон нартай холбон үздэг. Энэ хоёрын онолыг ерөнхийд нь ёс суртахууны мэдрэмжийн онол (moral sense theory) хэмээх нь бий. Тэдний үзлийг Дэвид Хьюм, Адам Смит тэргүүтэй философичид хөгжүүлэхдээ ёс суртахууны мэдрэмжийн талаарх санааг хойш тавьж, үүнийг симпати гэх зүйлээр орлуулсан байна. Улмаар сентиментализм английн ёс зүй, улс төрийн сэтгэлгээнд ихээхэн нөлөөтэй байж иржээ. Жишээлбэл утилитарианизм (сентименталист үзэл биш хэдий ч) бол түрүү үеийн сэтгэгчдийн юу зөв эсвэл буруу болохыг нинжин сэтгэл (benevolence), симпати гэх мэт бусдын зовлон, шаналалыг мэдрэх чадварт тулгуурлан тогтоох гэж оролддог байсныг өвдөлт болон таашаал мэдрэх чадвараар орлуулан тайлбарлах оролдлого байв. Үүгээр зогсохгүй Хьюмийн гаргаж тавьсан ‘байдаг (is) гэдгээс ёстой (ought) гэдгийг ургуулан гаргаж чадахгүй’ гэх санаа ХХ-р зууны философид ихээхэн нөлөөлсөн бий. Үр дүнд нь баримт үнэлэмж хоёрыг эрс ялгаатай зүйлс хэмээн үзэж, үйлдлийн зөв бурууг тогтоох биш харин ёс

суртахууны өгүүлбэр, нэр томъёонууд ямар утга илэрхийлдэг талаар судлахад гол анхаарлаа хандуулдаг экссессивизмд хамаарах сентиментализмын шинэ хувилбарууд бий болсон юм. Мөн Шаун Николс (2004), Майкл Слөүт (2010), Хайдт (2001) зэрэг өнөө үеийн сэтгэгчид сентиментализмийг орчин үеийн сэтгэл судлалын ололтуудаар баяжуулж улам боловсронгуй болгож байна.

Жулиа Драйверийн үзсэнчлэн ёс суртахууны сентиментализм хоёр суурь сэдэв дээр тогтдог (Driver, 2013). Нэгдүгээрт, сэдлийн тухай сэдэв: Аливаа хүнд ёс суртахуунтай үйлдэл хийх сэдэл төрүүлэхэд сэтгэл хөдлөл эсвэл хүсэл тэмүүлэл зайлшгүй шаардлагатай; Хоёрдугаарт эрх дархын (authority) тухай сэдэв буюу биднийг нэгтгэж барьдаг ёс суртахууны хэм хэмжээ нь тодорхой ёс суртахууны сентиментүүдээс эхтэй. Эдгээр санаа нь Гоббсын нийгмийн гэрээний онолоос урган гарсан эгоизм хийгээд ёс суртахууныг оюун ухаанд хамаатуулдаг рационалист үзлийг шүүмжлэх замаар бий болжээ. Гэхдээ энэ нь сентименталистууд оюун ухаан ёс суртахуунтай огтоос хамаагүй мэт үздэг гэсэн үг биш. Дийлэнх сентименталистууд хүнд байх өөрийн болон бусдын сэдэл, зан байдлыг тунгаах чадвар ёс суртахуунд шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэ чадварын ачаар л хүн сэдэл, зан байдал зэрэг зүйлсэд үнэлгээ өгөх буюу тэдгээрт зөвшөөрөл (approbation) эсвэл буруутгал оноох чадвартай болж буй хэрэг. Түүнчлэн хүний үйлдлийг чиглүүлдэг гол зүйл болох хүсэл тэмүүллийг (энэ нь нэг төрөл сентимент мөн) хэрхэн биелүүлэх арга замыг оюун ухаан олох үүрэгтэй тухай ярьдаг. Гагцхүү ёс суртахууны мэдрэмж эсвэл симпатигаа зохих ёсоор ашигладаг хүмүүсийн зөвшөөрөл (approbation) л юу ёс суртахуунтай, юу эрхэм чанартайг тогтоох шалгуур хэмээн үздэг нь ёс суртахууны төвд оюун ухаанаас илүү сентиментийг тавьж буйнх нь илрэл юм. Мөн Гоббс хүн бүхий л зүйлийг зөвхөн өөрийнхөө төлөө хийдэг төдийгүй ёс суртахуун, хууль цаазын хэм хэмжээнд захирагдаж байгаа явдал нь өөрөө урт хугацааны ашиг сонирхолоо ухамсарласны үр дүн л гэж үздэг. Харин сентименталистууд хүний нинжин сэтгэлд ач холбогдол өгдгөөрөө алтруист сэдлээр үйлдэл хийх боломжийг зөвшөөрдөг юм.

Шафтесбюри сайн чанар (goodness) гэдгийг аливаа зүйл өөрөө нэг хэсэг нь болж оршин буй тогтолцооныхоо оршихуй эсвэл сайн сайханд хувь нэмэр оруулах шинж хэмээн үздэг (Shaftesbury, 2001). Жишээ нь, нийт хүн төрөлхтний сайн сайханд эерэгээр нөлөөлөхүйц амьдардаг хүн бол сайн хүн, бүх хун шувуудад сайн нөлөө авчрахуйц амьдарч буй хун бол сайн хун болох аж. Энэ нь цааш зөвхөн өөрийн зүйлд бус бүхэл ертөнцөд сайнаар нөлөөлж буй эсэх тухай асуудалтай холбогдож, улам өргөжиж болох авч Шафтесбюри аливаа бодгалийн өөрийн төрөл, зүйлтэй ямар харилцаатай байгаад илүү анхаарсан байна (Rivers, 2005). Хэдийгээр энэ үзэл нь ёс суртахууныг үр дагаварт тулгуурлаж ойлгох утилитарианизмтай төстэй харагдаж байгаа ч, тэрээр сайн үйлдлийн цаана сайн сэдэл байх ёстойг давхар онцолдгийг мартаж болохгүй. Өөрөөр хэлбэл аливаа амьтан аргагүйн эрхэнд эсвэл тухайн нэг сайн зүйлээс өөр зорилгын төлөө үйлдэл хийгээгүй, харин өөрийн зүйлийнхэнд туслахыг нэн тэргүүнд зорьсон бол сайн үйлдэл хийсэнд тооцно (Shaftesbury, 2001).

Сэдлийг ийн онцолсон нь түүний сентименталист үзлийн цөм болох дотносол (affection) хэмээх өөр нэгэн ойлголттой нягт холбоотой. Дотносол бол аливаа амьд биесийн ямар нэг зүйлийг хүсэж тэмүүлдэг тэр тал юм. Чухам энэ дотносол амьд биест тодорхой үйлдэл хийх сэдэл төрүүлдэг бөгөөд оюун ухаан дангаараа сэдэл төрүүлж дийлдэггүй (Shaftesbury, 2001). Дотносол нь сэдэл төрүүлээд зогсохгүй амьтан аливаа зүйлд тэмүүлэх эсэхийг тодорхойлдогийнхоо хувьд юмсад үнэлгээ өгөх суурь бас мөн. Хэрэв ямар нэг зүйлийг сайхан эсвэл тустай гэж мэдрэхгүй бол түүнд тэмүүлэх боломжгүй юм, бас түүнтэй холбоотой үйлдэл хийх сэдэл ч төрөхгүй. Амьд биесийн дундаас зөвхөн хүн л өөрийн хүслийг ухамсарлаж (хүслээ хөндлөнгөөс харж) чаддаг.

Амьтан бол өөрийн хүслийг хөндлөнгөөс харж чадахгүй учир хүсэлдээ шууд автдаг байхад хүн хүслээ ухамсарлах чадварынхаа ачаар тэдгээрийг зөвшөөрөх, эс зөвшөөрөхөө шийдэх чадвартай. Ингэж хүслээ үнэлэх чадвартай учраас дотносолдоо чиглэсэн дотносол (нэг ёсондоо хоёрдугаар эрэмбийн дотносол) бий болгох чадвар бий (Shaftebury, 2001). Жишээ нь, хүн бусдыг дээрэмдэж, тонох хүсэлд автсанаа мэдээд үүндээ тавгүйцэж болно. Эсвэл бусдад сайныг үйлдэх хүсэлтэй байгаагаа анзаарч түүндээ дотносох боломжтой. Хоёрдугаар эрэмбийн дотнослыг Шафтесбюри заримдаа зөв буруугийн мэдрэмж, заримдаа ёс суртахууны мэдрэмж хэмээн томъёолдог (Rivers, 2005).

Шафтесбюри амьтад ёс суртахууны мэдрэмжгүй тул эрхэм чанарыг (dignity биш virtue-г хэлж байгааг анхаарна уу) амьтдад хамаатуулж болдоггүй хэмээн үзжээ (Shaftebury, 2001). Учир нь эрхэм чанар гэдэг бол зохих ёсоор ажиллаж буй ёс суртахууны мэдрэмждээ хөтлөгдөж үйлдэл хийх хандлага юм. Зохих ёсоор ажиллаж буй үедээ ёс суртахууны мэдрэмж нь хүнийг бусдын оршихуй хийгээд сайн сайханд хувь нэмэр оруулах үйлдлүүдэд чиглүүлнэ. Өөрөөр хэлбэл ёс суртахууны мэдрэмж нь хүн бүрд ялгаатай байж болдог төдийгүй өөр өөр зүйлсийг зөвшөөрч бас үл зөвшөөрөхөд хүргэх боломжийг нээлттэй үлдээдэг. Энэ асуудал судлаачдыг Шафтесбюри ёс суртахууны мэдрэмж гэдгээр чухам юуг ойлгож байсан талаарх маргааныг бий болгодог ба Шафтесбюри энэ тухайд зарим талаар дотооддоо зөрчилтэй мэт эсвэл бүрхэг утгатай зүйлсийг л бичиж үлдээжээ. Нэг талаас Сижвик (1902), Тувисон (1948) тэргүүтэй судлаачид зөв эсвэл буруу гэх мэт ёс суртахууны шинжүүдийг Шафтесбюри хүний мэдрэмжээс бүрэн хамаарах зүйл буюу хүний мэдрэмж нь объектив ертөнцөөс үл хамааран юу зөв эсвэл буруу болохыг өөрөө тогтоодог хэмээн үзсэн гэж тайлбардаг. Харин нөгөө талд, Айрвин (2008) тэргүүтэй судлаачид Шафтесбюригийн ёс суртахууны мэдрэмж нь бидний хариу үйлдлээс үл хамаарах объектив ёс суртахууны шинжийг таньдаг хэмээн үздэг байна.

Эцэст нь дурдах ёстой өөр нэг чухал зүйл бол Шафтесбюри ёс суртахууныг гоо зүйн линзээр харахыг илүүд үзсэн хэрэг юм. Түүнийхээр хүн юу сайхан, муухайг шууд мэдэрч, таньж чаддаг. Үүнтэй адилаар эрхэм чанарын дагуу үйлдэл хийх, сайн зүйлсэд тэмүүлэх нь ч бас хүнд сайханы (beauty) мэдрэмж төрүүлдэг ба сайхан гэдэг нь өөрөө юмсын тэнцвэртэй байдал, эв зохицлоос бий болж байдаг шинж юм. Энгийнээр хэлбэл ёс суртахуунтай байна гэдэг нь түүний хувьд сайхан эсвэл биширмээр зүйл буюу давхар гоо зүйн утгатай байжээ.

Шотландын соён гэгээрлийн өөр нэгэн төлөөлөгч Фрэнсис Хатчесон Шафтесбюригийн ёс зүй болон гоо зүйн онолыг өмгөөлөх маягаар өөрийнхөө философийг боловсруулжээ. Жишээ нь, 1725 онд хэвлэгдсэн *Сайхан хийгээд эрхэм чанарын талаарх өнөөгийн бидний санааны угшлын шинжилгээ* (Inquiry into the Original of Our Ideas of Beauty and Virtue) хэмээх бүтээлдээ Бернард Мандевиллийн өөдөөс Шафтесбюригийн үзлийг өмгөөлж, мөн лавшруулан тайлбарлахыг зорьсон байна (Darwall, 1995). Үнэхээр ёс суртахууныг гоо зүйтэй холбосон байдал, байгаль дээрх сайн чанарыг (natural goodness) ёс суртахууны сайн чанараас ялгасан байдал, ёс суртахууны мэдрэмжийг онцлон авч үздэг зэргээрээ тэдэнд төстэй тал олон юм. Гэхдээ Хатчесоны үзэл Шафтесбүрийнхээс юугаараа ялгарч байсныг доор авч үзье.

Хатчесоны үзлээс утилитарианизмын урьтал гэж болох олон санаа цухалзаж байдаг. Жишээ нь, сайн гэдэг нь аливаа зүйлийн ашиг тус өгөх тэр шинж бөгөөд ашиг тус гэдгээр тэр (Шафтесбюри системийнхээ сайн сайханд хувь нэмэр оруулах явдлыг хэлж байсан бол) таашаалыг ойлгож байжээ (Darwall, 1995). Утилитари үзэлтнүүд ч сайныг таашаалтай ижил хэмээн үздэг билээ. Утилитариануудын хувьд сайн бол сайн

л байсан юм. Өөрөөр хэлбэл тэд сайн гэдэг шинжийг дотор нь өөр өөр төрөлд ангилахад анхаараагүй. Харин Хатчесон байгалийн сайн чанарыг (natural goodness) ёс суртахууны сайн чанараас зааглан авч үздэг. Таашаал дангаараа бол түүний хувьд байгалийн сайн чанарыг илтгэхээс биш ёс суртахууны хувьд юу сайн эсвэл муу болохыг зааж дөнгөхгүй.

Ёс суртахууны сайн чанар гэдэг бол хүний сэдэл хийгээд тэрхүү сэдлээ дэнслэх чадварт л хамаатай юм. Хүн өөрийн хүсэл эсвэл дотнослыг тунгаах (reflect) чадвартай бөгөөд чухам үүнийхээ ачаар аливаад ёс суртахууны үүднээс зөвшөөрөл (approbation) эсвэл буруутгал оноож чаддаг тухайд Хатчесон Шафтесбюритэй санал нийлдэг ч гэлээ ийн дэнслэх чадварыг өөрийг нь ёс суртахууны мэдрэмжтэй адилтгаж үзээгүйгээрээ ялгаатай. Түүнийхээр бол хүн ёс суртахууны хувьд юу сайн бас муу болохыг шууд таних мэдрэмжтэй байдаг. Энэ нь нэг төрлийн дотоод мэдрэхүй (internal sense) бөгөөд хараа, сонсгол гэх мэт мэдрэхүйнүүд юмсын өнгө, чимээ зэргийг ялгадаг бол ёс суртахууны мэдрэмж нь аливаа үйлдэл, дотносол, зан байдлаас (character) нинжин сэтгэлийг (benevolence) ялгаж мэдрэх үүрэгтэй (Hutcheson 1969). Нинжин сэтгэл бол бусад хүмүүсийн сайн сайханд анхаардаг. Иймд эрхэм чанартай (virtuous) хүн бол нинжин сэтгэлтэй хүн, ёс суртахуунтай үйлдэл бол нинжин сэтгэлийн үүднээс хийж буй үйлдэл, ёс суртахууны хувьд сайн гэдэг бол бусдын сайн сайханд анхаарч буй явдал юм. Хэрэв ёс суртахуун нинжин сэтгэлд тулгуурлдаг бол ёс суртахууны хэм хэмжээ, алба үүрэг хүний хувийн ашиг сонирхлоо бодох хандлагаас урган гардаг гэх эгоист үзэл худал болж таарах билээ.

Ёс суртахууны мэдрэмжийг хүнд заяамал хэмээх үзэл нь Хатчесоны шашны баримтлалтай холбогддог. Сайн, мууг ялгах мэдрэмжийг Эзэн тэнгэр хүний сэтгэлд суулгасан байдаг аж. Үүгээр зогсохгүй ёс суртахууны мэдрэмжийг хүнд суулгасан явдал нь өөрөө Эзэн тэнгэр сайн болохын нотолгоо болдог (Hutcheson, 1969). Үнэндээ Шотландын соён гэгээрэлд, тэр тусмаа Хатчесоны үзэлд тухайн үед Шотландад ноёлох шашны урсгал болоод байсан калвинизм ихээхэн нөлөөтэй байжээ (MacIntyre, 1988). Ёс суртахууны мэдрэмжийн талаарх түүний баримтлал Паулын ромчуудад хандсан захидалд “Харийнхан хуульгүй боловч хуулийн шаарддаг зүйлсийг зөнгөөрөө үйлдвэл, хэдийгээр хуульгүй авч тэдгээр нь өөрсдөд нь хууль болдог. Хуулийн шаарддаг зүйлс зүрхэнд нь бичигдсэнийг тэд ийнхүү харуулж байна.” (Ариун Библи, 2013, Romans 2:14-15) гэх санаатай төстэй байгаа юм.

Сайхан хэмээх шинжийн тухайд, Шафтесбюри сайн, сайхан хоёрыг нэг зүйл мэт үзсэн байдаг. Хатчесон бол тэдгээрийн аль аль нь юмсад өөрт нь дангаар оршин байдаг шинж биш харин өнгө, чимээ зэрэгтэй ижил хүний хариу үйлдлийн дүнд бий болдог буюу Локкийн хоёрдугаар чанарын шинжүүдтэй ижилхэн гэдгээр нь адилтаж байсан ч ёс суртахууны мэдрэмжийг сайхны мэдрэмжтэй яг ижил мэт үзээгүй. Сайхны мэдрэмж нь юмсын эв зохицол, тэнцвэрийг барьж авдаг бол ёс суртахууны мэдрэмж нь нинжин сэтгэлийг таньдаг учир ялгаатай юм (Darwall, 1995).

Дэвид Хьюм ёс суртахууны үндсийг оюун ухаанаас эрэх нь буруу, хүний үйлдэл цор ганц хувийн ашиг сонирхолд хөтлөгддөггүй зэрэг түрүү үеийн сентименталистуудын үзлийг хадгалж үлдсэн ч ёс суртахууны мэдрэмж гэх ойлголтыг хэрэглэхээс татгалзжээ. Тэр дундаа Эзэн тэнгэрийн хүнд суулгаж өгсөн зөв, буруугийн мэдрэмжийн тухай санаанаас сентиментализмыг салгасан байна. Харин үүнийг симпати хэмээх зүйлээр орлуулахыг дээрд үзэв. Хьюмийн үед хэрэглэж байсан симпати хэмээх үг нь орчин үеийн эмпати гэх үгтэй бараг л ижил утгатай. Гэхдээ симпати нь бусдын зовлон шаналлыг ойлгож хуваалцах чадварыг л түлхүү илэрхийлдэг бол өнөөгийн эмпати гэх ойлголт нь эерэг, сөрөг мэдрэмжийн аль алийг

хуваалцаж, ойлгох чадварыг илэрхийлдэг. Тус хоёр ойлголтын өөр нэг ялгаатай тал нь сипатиг бид хэн нэг хүний зовлонг зүгээр л мэдрэх бус харин түүний сайн сайхан байдалд анхаарал хандуулах байдлыг илтгэж болдог бол эмпати нь хүний сайн сайханд анхаарал хандуулах явдлыг илэрхийлдэггүй (Slote, 2010).

Эмпатиог когнитив болон аффектив хоёр төрөлд ангилан авч үзэх хандлага бий (Terjesen, 2013). Аффектив эмпати нь мэдрэмж халдах үзэгдэлтэй төстэй буюу хүн эргэн тойрондоо байгаа хүмүүстэй ижил мэдрэмжийг шууд мэдрэх чадварыг заадаг. Жишээ нь, хэн нэг хүн баярлаж, инээж байхыг харсан түүнтэй хамт байгаа өөр нэг хүн дагаад баярлаж болно. Когнитив эмпатид харин төсөөлөх чадвар хэрэгтэй. Нэг ёсондоо энэ бол хүн өөрийгөө бусдын оронд тавьж үзэх чадвар юм. Хьюмийн хувьд симпатиог аффектив утгаар ойлгож байжээ. *Хүний уг чанарын тухай шастир* (A Treatise of Human Nature)-таа бичсэнээс нь үзвэл симпати нь сэтгэл хөдлөлийн халдвартай төстэй зүйл болж таардаг. Энэ үүднээс бол амьтад болон хүний аль аль нь симпатитай гэсэн үг юм. Энэ талаар тэр нохдын жишээг дурдсан бий: “Ноход сүргээрээ ан хийх үедээ, салангид тусгаар байх үеийнхээсээ хэчнээн идэвхтэй болдгийг бүгд л харж байсан байх; үүний учир нь симпатинаас өөр зүйл байх аргагүй юм” (Hume, 1978, 2.2.12). Амьтад симпатитай боловч түүнийгээ тунгааж, үнэлгээ өгөх чадваргүй тул хүн шиг ёс суртахуунтай байж чаддаггүй.

Ёс суртахууны зарчмуудын талаарх шинжилгээ (An Enquiry Concerning the Principles of Morals) хэмээх дараагийн бүтээлдээ Хьюм Симпатиог нинжин сэтгэлтэй илүү холбон авч үзжээ. Энэ үүднээс бол симпати нь бусдын сэтгэл хөдлөлийг мэдрэх төдийгөөр зогсохгүй, бусдад хандсан анхаарал, халамжийг давхар илэрхийлдэг. Чухам ингэж анхаарч, ач холбогдол өгөх чадвар нь аливаа үйлдэл, зан байдлыг ёс суртахууны хувьд зөвшөөрөх эсвэл буруутгах үндэслэл болдог (Driver, 2013). Хүн ингэж нэг нэгийнхээ сайн сайхан эсвэл зовлон шаналалд анхаарал хандуулдаг учраас л ёс суртахууны хэм хэмжээ аяндаа бий болж, хүмүүс хамтаараа зохицон амьдрах боломж бүрддэг (Hill, 1987). Энэ нь хүмүүс хоорондоо зориудаар гэрээ байгуулсны дүнд ёс суртахууны хэм хэмжээ бий болж, хамтын амьдрал тогтох боломжтой гэх Гоббсын санаатай эсрэгцдэг. Хьюм хүн симпати хэмээх төрөлх чадвараа хөгжүүлэх шаардлагатайг онцлохын зэрэгцээ хүмүүс зөвхөн ойр, дотнын хүмүүсийнхээ сайн сайхан, зовлон шаналалд ач холбогдол өгдөг, харин хол хөндий хүмүүсээ төдийлөн тоодоггүй болохыг анхаарч байв. Иймд түүний хувьд улс төр, практик ёс зүйн нэг чухал асуудал нь хүмүүст зөв боловсрол түгээж, симпатины хамрах хүрээг нь өргөжүүлэх явдал байсан юм.

Ёс суртахууны үүднээс юу сайн эсвэл муу болохыг шууд таньдаг ёс суртахууны мэдрэмж биш бусдын мэдрэмжийг хуваалцах л үүрэг бүхий симпатиог ёс суртахууны төвд оруулж ирсэн нь Хьюмийн ёс суртахууны баримтлалыг зарим талаар релятивизмд хамаатуулах үндэслэл болдог. Хүн бүрийн зөвшөөрөх, буруутгах зүйл ялгаатай байдаг бол нэгдмэл ёс суртахууны хэм хэмжээг гаргаж ирэх нь төвөгтэй болох билээ. Гэхдээ Хьюм ёс суртахуунтай байдал хийгээд эрхэм чанар гэдэг бол хүн бүрд таатай санагддаг зүйл биш харин ерөнхий харах өнцгөөс (general point of view) харж буй ажиглагчид л тааламжтай санагдах зүйлс хэмээн тодорхойлжээ. Ерөнхий харах өнцөг гэж чухам юу болох нь бүрхэг байдаг хэдий ч энэ бол хүний үнэлгээг гажуудуулж байдаг буруу ойлголт, мэдээллийн хомс байдал, өрөөсгөл хандлага зэргээс ангид байх тэр төлөвтэй холбоотой гэдэг нь түүний бичсэнээс ойлгогддог (Driver, 2013).

Хатчесоны (1694-1746) шавь, Хьюмийн (1711-1776) найз байсан Адам Смит (1723-1790) Хьюмийг дагаж ёс суртахууны эх үндэсийг симпати гэх сентимент хэмээн үзжээ. Ингэхдээ симпати нь хязгаарлагдмал хүрээнд л үйлчлэх хандлагатай байдаг бол

энэ дутагдлыг нь засварлаж, ёс суртахууны үнэлгээг хэрхэн үл алагчлах хандлагад тулгуурлаж хийх, цаашлаад хэм хэмжээ гаргаж авах талаарх асуудалд ихээхэн төвлөрсөн нь харагддаг. Энэ нь түүнийг орчин үеийн идеал ажиглагчийн онол эсвэл Роулсын үл мэдэхүйн гивлүүрийн тухай санаатай төстэй шийдэлд хүргэсэн бий.

Смитийнхээр хүмүүс нэг нэгийнхээ мэдрэмжийг шууд, байгаагаар нь хүлээж авч чадахгүй учраас тэднийг ойлгож чаддаггүй, иймд өөрсдийгөө мөнөөх хүмүүстэй ижил нөхцөлд байна гэж төсөөлөх буюу нэг ёсондоо өөрийгөө тэдэнтэй ижилхэн хүн болсон мэтээр төсөөлөх хэрэгтэй болдог (Smith, 2002). Орчин үеийн хэллэгээр бол Смит аффектив эмпатинаас илүүтэйгээр когнитив эмпатиг ёс суртахууны эх үндэс болгохоор оролдсон аж.

Мөн тэр хүмүүс ёс суртахууны хувьд зөв эсвэл буруу гэх үнэлгээг хэрхэн симпатид тулгуурлаж хийдэг талаар тайлбарлаад зогсохгүй ёс суртахууны үнэлгээг яаж хийвэл илүү зохимжтойг авч үзэхээр оролджээ (Driver, 2013). Ингэхдээ хүмүүсийг ёс суртахууны үнэлгээгээ үл алагчлах хандлагатай ажиглагч (impartial spectator) буюу хүн бүрийг ойр эсвэл холын гэж ялгалгүйгээр ижил хандаж чадах нэгэн симпатидаа тулгуурлаад юуг зөвшөөрч, юуг буруутгах байсан түүнтэй нийцэх хэлбэрээр үнэлгээгээ өгөх хэрэгтэй хэмээн үзсэн юм.

19-р зуунд сентиментализмын залгамж халааг Англид утилитарианизм авав. Харин Германд 18-р зууны сүүлийн хагаст Кант Хьюмийн философийг хувиргаж эрс гэмээр рационалист хэлбэр бүхий ёс суртахууны философи боловсруулж гаргасан билээ. Хүн тус бүрийн үнэ цэнийг адил тэгш харах, ёс суртахууны хэм хэмжээг оюун ухаан эсвэл Эзэн тэнгэрийн тушаалаас илүү хүний мэдрэмжид тулгуурлан гаргаж авахыг илүүд үздэг зэрэг нь утилитарианизм, сентиментализм хоёрын хамгийн чухал төсөөтэй талууд мөн. Гэсэн ч утилитарианууд ашиг тусыг тоогоор тооцоолж болох, нинжин сэтгэлээс үл хамаарсан зүйл хэмээн хардаг байхад сентименталистуудын хувьд ашиг тус нь нинжин сэтгэлээс салшгүй зүйл байдаг. Сентиментализм 19-р зууны өрнийн ёс суртахууны философийг олон талаар хэлбэржүүлсэн авч сентиментализмд хамаарахуйц хүчтэй философи үзэл хорьдугаар зуун хүртэл гарч ирээгүй байдаг.

Хорьдугаар зууны эхээр философи нь хэлтэй холбоотой асуудлуудыг тойрон эргэх болов. Ёс зүйн асуудал ч сайн гэж юу болох вэ гэдгээс урьдаар сайн гэх үг ямар утгатайг тодруулахыг зорьдог боллоо. Үр дүнд нь ёс зүйн экспрессивизм хүчээ авчээ. Эхэн үеийн экспрессивистүүдийг Айер, Стивенсон зэрэг эмотивистуудаар төлөөлүүлдэг. Тэднийхээр “х бол сайн” гэх мэт баталсан өгүүлбэрүүд х-д сайн гэдэг шинж байгааг баталж хэлдэг биш харин х-ийн талаар субъектэд төрж буй сэтгэгдлийн гадаад илэрхийлэмж л болдог.

Нэг талаар ‘сайн’ гэх үг чухам ямар утгатайг шинжлэхдээ Мур-ийн гаргаж тавьсан нээлттэй асуултын үндэслэл (Moore, 1903) сайн гэдэг шинжийг бид байгаль дээрээс олох ч боломжгүй, тодорхойлох ч аргагүй гэдгийг тод харуулсан нь эмотивистууд гарч ирэх нэг чухал суурь болжээ. Хамгийн чухал нь, Мур хүмүүс сайн хэмээх объектив шинжийг тодорхойлж эсвэл эмпирикээр мэдэж чадахгүй хэр нь ямар нэг өвөрмөц интуицээр дамжуулан шууд мэддэг гэх маягаар ёс суртахууны хэм хэмжээний объектив талыг үндэслэхээр оролдсон нь олон хүнд үнэмшилгүй санагдаж, шүүмжлэл дагуулсан байдаг.

Дээрхтэй зэрэгцээд, логик позитивистууд бодит байдлыг дүрсэлж, үнэнийг илэрхийлж чаддаг өгүүлбэрүүдийг тийм биш өгүүлбэрүүдээс ялгах асуудлыг ихэд чухалчилж байв. Тэд верификацийн зарчимдаа тулгуурлан зөвхөн логик, математикийн бодомжууд хийгээд эмпирик ертөнцийн талаарх өгүүлбэрүүд (баримтууд) л үнэн бөгөөд объектив утгатай байдаг хэмээн тунхаглаад гоо зүй, ёс зүй

зэрэг үнэлэмжийн шинжтэй салбаруудыг бүхэлд нь утгагүй зүйл хэмээн үзсэн нь эмотивист санаа хүчээ авах өөр нэг чухал хөшүүрэг болжээ.

Үнэндээ баримт бол ертөнцийг байгаагаар нь дүрсэлдэг (үнэнийг илэрхийлдэг) байхад үнэлэмж тэгж чаддаггүй хэмээх санаа нь Хьюмийн ‘байдаг’ (is) гэдгээс ‘ёстой’ (ought) гэдгийг гарган авч чадахгүй гэх сонгодог санааны л цуурай болж таардаг (Putnam, 2002). Энгийнээр тайлбарлавал, дайнд үй олон хүний амь эрсддэг, үүнээс болж олон хүн зовдог гэх мэтээр дайны талаарх хэчнээн ч баримтыг тоочсон бай энэ нь хүнд дайн хийх ёстой (дайн бол сайн) эсвэл ёсгүй (дайн бол муу) гэдгийг хэлж чаддаггүй. Хэрэв дайн сайн эсвэл муу эсэхийг баримтаар шийдэж чадахгүй юм бол верификацийн зарчмын үүднээс “дайн бол муу” гэх баталсан өгүүлбэр үнэн ч биш, худал ч биш юм. Гэтэл “цас бол цагаан” гэдэг өгүүлбэрийн тухайд бол цас гэх зүйлд цагаан гэдэг шинж объективоор байгаа гэдгийг баримтаар үндэслэхэд маргах зүйл хавьгүй бага билээ.

Гэхдээ “х бол сайн” гэх мэт ёс суртахууны баталсан өгүүлбэрүүд аливаа х-д сайн гэх шинж байгаа талаар өгүүлдэггүй бол чухам юуг илэрхийлдэг болж таарах вэ? Эмотивистуудын хувьд энэ бол “цас цагаан” гэдэг шиг жинхэнэ баталсан өгүүлбэр ч биш, зүгээр л баярласандаа янз бүрийн хөдөлгөөн гаргах, нүүр хувирах, хоолойны өнгө өөр болох зэрэгтэй ижилхэн сэтгэл хөдлөлийн илэрхийлэмжээс өөрцгүй зүйл юм. Энэ нь нэг талаар субъектив релятивизмыг эмотивизмоос ялгах үндэслэл мөн. Субъектив релятивистууд ёс суртахууны өгүүлбэрүүдийг жинхэнэ баталмал өгүүлбэр мөн гэдгийг хүлээн зөвшөөрдөг авч түүний үнэн эсэхийг хувь хүн тус бүр өөр өөрөөр тодорхойлох боломжтой гэж үздэг. Гэтэл эмотивистууд мөнөөх өгүүлбэрүүдийг нүүрний хувирал мэт илэрхийлэмжүүдтэй жишсэнээрээ үнэн, худлын утга огтоос авах боломжгүй зүйл болгож орхидог.

Алфред Жулс Айер *Хэл үнэн ба логик* хэмээх номынхоо зургаадугаар бүлэгт ёс суртахууны баталмал өгүүлбэрүүд ямар утгатай талаар авч үзсэн бий. Түүнийхээр үнэлэмжийн шинжтэй ойлголтуудыг хүмүүс нэгдүгээрт, тодорхой бүлэг хүмүүсийн хандлагыг илэрхийлэхдээ эсвэл хувийн хандлагаа илэрхийлэхдээ ашигладаг (Ayer, 1936). Жишээ нь, Монгол хүн ‘голд сүү дусаах нь муу’ гэж хэлбэл энэ нь голд сүү дусаах гэдэг үйлдэлд муу гэдэг ямар нэг шинж буй тухай бус харин монголчууд голд сүү дусаахыг зөвшөөрөхгүй байгаагийн илрэл байж болно. Түүнчлэн нэг хүн ‘дээрэм хийх нь муу’ гэж хэлэх нь дээрэм хийх явдал өөрт нь таалагдахгүй байгааг л илэрхийлж байгаа хэрэг. Гэхдээ эдгээр нь ‘голд сүү дусаах нь монголчуудад таалагдахгүй байна’ эсвэл ‘дээрэм хийх нь надад таалагдахгүй байна’ гэх мэт соёл эсвэл субьектэд буй төлөвийн талаарх баримтыг ч илэрхийлдэггүй. Түүний үгээр бол сайн, зөв гэх мэт үгс хурайлах, муу, буруу гэх мэт үгс англи хэлтэй хүмүүс дургуйцлээ илэрхийлэхдээ ашигладаг ‘бүү’ гэх авиатай л адил (хурайлалт үнэн эсвэл худлыг хэлнэ гэж үгүй). Үүнээс нь улбаалан эмотивизмийг *boo-hurray* онол гэж томъёолох нь ч бий.

Одоо эмотивистуудыг яагаад сентименталист хэмээж болох тухайд авч үзье. Юуны түрүүнд эмотивистууд ёс суртахууны ойлголтуудыг сэтгэл хөдлөлийн утгатай хэмээсэн нь ёс суртахууныг хүний сентименттэй салшгүй холбоотой гэх сонгодог сентименталист санааны илэрхий тусгал болдог. Үнэн хэрэгтээ сонгодог сентименталистуудад сэтгэл хөдлөл (emotion) гэх ойлголт байгаагүй бөгөөд сентимент гэх толгой ойлголт дор хүсэл тэмүүлэл, төрөл бүрийн мэдрэмжүүд, бидний өнөө үед сэтгэл хөдлөл гэж нэрлэх болсон тэр зүйлсийг багтаан ойлгодог байж ээ (Slote, 2010). Хоёрдугаарт, эмотивистуудаас ёс суртахууны зөвшөөрлийн (moral approbation) талаарх санаа илэрхий ханхалж байдаг. Сонгодог сентименталистууд ёс суртахууны хувьд сайн эсвэл муу болох зүйлийг тодорхой мэдрэмж бүхий үйл эрхлэгч

(agent) зөвшөөрөх эсвэл буруутгах эсэхээс хамаарна гэж үздэг билээ. Нэг ёсондоо сайн үйлдэл гэдэг бол тэдний хувьд нинжин сэтгэлтэй хүн хараад хурайлж болох тийм л үйлдэл юм. Эмотивистуудын ялгаа гэвэл ёс суртахууны хэм хэмжээг үндэслэх үүрэгтэй байсан нинжин сэтгэл гэх эрхэм чанарыг (virtue) үгүй хийсэн явдал билээ.² Сонгодог сентименталистууд хүн бүрийн зөвшөөрөл, буруутгалыг ижилд үзэж байгаагүй. Зарим хүн дутуу мэдээлэл, ерөөсгөл ойлголтоосоо болоод алдаатай зөвшөөрөл, буруутгал хийх боломж байдгийг зөвшөөрдөг. Харин эмотивистуудын хувьд хүн бүрийн зөвшөөрөл, буруутгал тэнцүү хүчтэй болж таардаг. Нинжин сэтгэлтэй хүний зөвшөөрч буй зүйлд нинжин биш хүнийхээс дээр гарах зүйл үгүй. Товчхон хэлбэл эмотивизм гэдэг нь ёс суртахууны хэм хэмжээг зөвтгөх (justify) чадвараа алдсан сентименталист онол л юм.

Экспрессивистүүд (нон-когнитивистууд ч гэдэг) ёс суртахууны нэр томъёонуудыг утгагүй хоосон илэрхийлэмж гэж үзсэн нь нэгэн энгийн логик дүрэмтэй зөрчилддөг. Петер Гич (Geach, 1958) Фрегегийн логикт тулгуурлан тэрхүү асуудлыг сөхөн тавьсан нь Фреге-Гичийн асуудал гэх нэрээр алдартай болжээ. Тус асуудлыг энгийнээр томъёолбол хоёр үндсэн сэдвээс тогтож байдаг. Нэгдүгээрт, аливаа үг өөртэйгөө ижил утгатай байх ёстой. Өөрөөр хэлбэл сайн гэдэг үг ямар хэлбэрийн өгүүлбэрт байгаагаасаа үл хамаараад нэг утгаа хадгалж байх учиртай. Хоёрдугаарт нон-когнитивистуудыг дагах юм бол ёс суртахууны нэр томъёонуудыг баталмал хам сэдвийн хүрээнд (assertive context) хэрэглэх үед баталсан бус хам сэдвийн хүрээнд хэрэглэхээс ялгаатай утгатай болж таарна.

Баталсан хам сэдэвт хэрэглэж байна гэдэг нь “Х бол муу” гэх мэт дан баталмал бодомжуудад орсон байдлыг хэлнэ. Баталсан биш хам сэдэвт хэрэглэсэн байна гэдэг нь логик холбоосоор нийлсэн нийлмэл бодомжид орсон, асуух өгүүлбэрт орсон тохиолдол зэргийг зааж болно. Ойлгомжтой болгохын тулд *модус поненс* дээр жишээ авч үзье. *Модус поненс* бол нэг төрлийн логик хэлбэр бөгөөд бодомжуудын логик холбоонд тулгуурлаж аливаа бодомж гарцаагүй үнэн байхыг үндэслэдэг ба дараах бүтэцтэй байна:

(нөхцөл 1) *A*

(нөхцөл 2) *Хэрэв A бол B*

(дүгнэлт) *Иймд B*

Одоо үүнийг нохойны талаарх эргэцүүлэл болгож хувиргая:

(нөхцөл 1) *Нохой дөрвөн хөлтэй*

(нөхцөл 2) *Хэрэв нохой дөрвөн хөлтэй бол нохойн гөлөг дөрвөн хөлтэй*

(дүгнэлт) *Иймд нохойн гөлөг дөрвөн хөлтэй*

Модус поненс-ын дагуу нөхцөлүүдээсээ нохойн гөлөг дөрвөн хөлтэй гэх дүгнэлтийг асуудалгүй гарган авч болж байна. Одоо ёс суртахууны нэр томъёотой жишээгээр орлуулаад үзье.

(нөхцөл 1) *Муур тамлах нь буруу*

(нөхцөл 2) *Хэрэв муур тамлах нь буруу бол дүүгээрээ муур тамлуулах нь буруу*

(дүгнэлт) *Иймд дүүгээрээ муур тамлуулах нь буруу*

² Сонгодог сентименталистуудын норматив онолыг өнөө үед эрхэм чанарын ёс зүйд (virtue ethics) хамаатуулж үзэх хандлагатай байдгийг дурдах нь зөв.

Энэ тохиолдолд нөхцөл 1-д буй ‘муур тамлах нь буруу’ гэх өгүүлбэр баталмал хам сэдэв дотор байгаа бол нөхцөл 2-т буй ‘муур тамлах нь буруу’ гэдэг нь баталсан биш болзол тавьсан шинжтэй байна. Одоо эмотивист линзээр силлогизмоо харах юм бол нөхцөл 1-ийг нон-когнитив утгаар буюу муур тамлах талаар дуулаад ‘бүү’ гэх авиа гаргах явдал хэмээн үзэж болж байна (тийм бол үүнд үнэн, худлын утга оноох аргагүй). Харин нөхцөл 2 дээр буй ‘муур тамлах нь буруу’ гэдэг өгүүлбэрийг ингэж нон-когнитив утгаар харж болохгүй. Учир нь нөхцөл 2 маань болзолт нийлмэл бодомж учраас ‘хэрэв *A* үнэн бол *B* үнэн’ гэх санааг илэрхийлснээрээ *A*-д үнэний утга авах боломж олгож байгаа юм. Тийм бол хоёр нөхцөлд буй ‘муур тамлах нь буруу’ гэх бодомжийн утга ялгаатай гэсэн үг. Үр дүнд нь эмотивизм логик хуультай зөрчилддөг болж таарлаа.

Саймон Блэкбурн (Blackburn, 1984, 1993) тус асуудлын гол зангилааг ёс суртахууны нэр томъёонууд бодитоор оршдог шинжийг заадаг (refer) хэмээн үзэх нь дэндүү үнэмшилгүй байхад яагаад мөнөөх нэр томъёог ашигласан өгүүлбэрүүд үнэн, худлын утга авдаг мэт харагдаад байгаа явдал хэмээн үзсэн байна. Мөн тус асуудлын шалтгааныг тайлбарлаж, экспрессивизмийн илүү боловсронгуй хувилбар боловсруулахаар зорьсон бий. Ингэхдээ тэр үнэний талаарх тохирооны онолыг уг будилааны эх ундарга гэж үзээд түүнийг үнэний талаарх минималист онолоор орлуулахыг оролдсон юм.

Тохирооны онолчид аливаа бодомж (баталмал эсвэл үгүйсгэл өгүүлбэр) үнэн байхын тулд бодит байдалтай тохирч байх ёстой хэмээн үздэг. Гэтэл ёс суртахууны өгүүлбэрүүдэд буй предикатуудын заадаг шинжүүдийг оршдог хэмээн үзэхэд тун жигтэй зүйл байсан учраас, үнэн, худлын утга огтоос авах боломжгүй хэмээн үзжээ. Харин Фреге-Гичийн асуудлын харуулж байгаачлан, аливаа бодомж логик систем дотор байгаа үедээ үнэний утга авах бүрэн боломжтой зүйл болж таарч байгаа юм. Тохирооны онолыг дагавал тус бодомжууд үнэний утга авах боломжтой байгаа нь ёс суртахууны шинжүүд бодитоор оршдог гэх үндэслэл болж буй мэт харагдана. Блэкбурн харин логик систем дотор ёс суртахууны бодомжууд үнэн худлын утга авах боломжтой гэдгээс ёс суртахууны шинжүүд бодитоор оршдог гэх реалист үзэлрүү үсрэх нь асуудалтай гэдэг дээр бат зогсдог.

Үнэний талаарх минимал онолын үүднээс бол үнэн гэх предикат нь хүмүүст өөрсдийнхөө итгэж, зөвшөөрч буй бодомжуудын талаар өгүүлэх боломж олгодог логик хэрэгсэл төдий зүйл болохоос өгүүлбэр болон бодит байдлын тохироон дундаас үүсдэг өвөрмөц шинжийг заасан нэр ердөөс биш. Үнэнийг ийн үзэх аваас Фреге-Гичийн асуудал дээр ёс суртахууны бодомжууд ижилхэн үнэний утга авч болох ч гэлээ үүнээс болоод ёс суртахууны реализмыг хүлээн зөвшөөрөх албагүй юм. Ёс суртахууны бодомжууд зөвхөн өнгөн хэсэгтээ бодитой зүйлсийн талаар өгүүлж буй мэт боловч үнэн хэрэг дээрээ огтоос тийм биш гэх түүний үзлийг квази-реализм (quasi-realism) хэмээдэг.

Одоо квази-реализмын экспрессивист талыг авч үзье. Блэкбурн хожуу үедээ хандах чадамжийн онол (sensitivity theory) гэх зүйлээ консерватив бардамналыг дэмжих хэрэгсэл болдог учраас орхих хэрэгтэй хэмээсэн байдаг (Blackburn, 1998). Гэвч уг онол нь түүний экспрессивизмийн чухал хэсэг гарцаагүй мөн учир авч үзэхээс аргагүй юм. Хандах чадамж (sensitivity) гэдэг нь аливаа үйлдэл эсвэл юмс, үзэгдэлд янз бүрээр хандах байдлыг илэрхийлнэ. Жишээ нь, зүй бус зүйлийг хараад уурлах, зовж буй хүнийг хараад өрөвдөх, баатарлаг үйлийг хараад бишрэх гэх мэт. Хүн бүрд өөрийн гэсэн өвөрмөц мэдрэх чадвар байна. Өөрөөр хэлбэл хүн бүр өөр өөр зүйлсэд, өөр өөрөөр ханддаг. Хүмүүс хандах чадамжуудаа хооронд нь харьцуулж заримыг нь илүүд

үздэг (Blackburn, 1984). Үүгээр зогсохгүй, ийн илүүд үзэх хандлага маань хоорондоо зөрчилтэй байж болохгүй. Бид хоорондоо зөрчилтэй үйлдэл хийдэг хүмүүсээс зөрчилгүй үйлдэл хийдэг хүмүүсийг илүүд үздэг. Хүний хандах чадамжууд хоорондоо зөрчилтэй байх аваас түүнийг ‘хагархай хандах чадамжтай’ (fractured sensibility) хүн хэмээнэ.

Блакбурн экспресивист уламжлалаа даган ёс суртахууны бодомжууд бодит байдлыг дүрсэлдэг бус хүний хандах чадамжийн илэрхийлэл болдог хэмээн үздэг. Харин энэ нь Фреге-Гичийн асуудлыг тойрон өнгөрч чаддаг. Урьдын жишээгээ дахин үзвэл:

(нөхцөл 1) *Муур тамлах нь буруу*

(нөхцөл 2) *Хэрэв муур тамлах нь буруу бол дүүгээрээ муур тамлуулах нь буруу*

(дүгнэлт) *Иймд дүүгээрээ муур тамлуулах нь буруу*

Муур тамлах нь буруу гэдгийг зөвшөөрч буй хүн хэрэв эрүүл ухаантай (хагархай хандах чадваргүй) бол дүүгээрээ муур тамлуулахыг ч бас буруу гэдгийг зөвшөөрөх хандлагатай байна. Ийм маягаар Блакбурн ёс суртахууны бодомжууд хүний хандлагыг илэрхийлдэг авч логик систем дотор үнэний утга авах боломжтойг нотлон харуулдаг.

Ёс суртахууны хэм хэмжээг нэг талаас рационалистууд оюун ухаан ба түүний таньж эсвэл бүтээх бололцоотой дүрэм зарчмуудад үндэслэх хандлага нөгөө талаас сентименталистууд хүний мэдрэмж, хандлагаар тайлбарлах гэсэн маргаан өрнөсөөр өнөө үед талууд эмпирик сэтгэл судлалын ололтуудыг ашиглан үндэслэлээ дэвшүүлэх болов. Үнэндээ орчин үеийн мета ёс зүй болон норматив ёс зүй ямар нэг байдлаар эмпирик сэтгэл судлал, тархи судлалын ололтод суурилалгүйгээр жинтэй үндэслэл дэвшүүлэх боломж хомс болж буй билээ.

Шаун Николс *Сентиментал дүрмүүд* (2004) хэмээх номдоо неосентиментализмын нэг хувилбарыг боловсруулсан бий. Түүрүү үеийн сентименталистууд ёс суртахууны шийдэмжид норматив дүрмүүдэд суралцах явдлын үүргийг төдийлөн онцолж үзэж байсангүй. Харин тэднээс ёс суртахууны дүрэм яагаад байдаг талаар асуувал ёс суртахууны сентимент байдаг учраас гэх хариулт өгөх болно. Харин Николс ёс суртахууныг норматив дүрэм, сэтгэл хөдлөл хоёрын харилцан үйлчлэл дундаас бий болдог зүйл хэмээн үздэг. Үнэндээ дүрэм, зарчим зэрэг нь рационалистуудын ёс суртахууныг үндэслэх гол хэрэгсэл байж ирсэн юм. Энэ үүднээс Николсын неосентиментализм бол хоорондоо эсрэгцдэг хоёр үзлийг нэгтгэх оролдлого байсан хэмээн үзэж болно.

Николсынхоор хүн аливаа зүйлийг ёс суртахууны үүднээс үнэлж, дүгнэхэд хоёр зүйл шаардлагатай бөгөөд аль нэг нь үгүй бол ёс суртахууны шийдэмж байх ямар ч боломжгүй: нэгдүгээрт, аливаа үйлдэлд үзүүлэх аффектив хариу, хоёрдугаарт ямар үйлдэл хориотой болох талаарх норматив онол. Энэ хоёр бүрдлийг нийлүүлбэл түүний онолын цөм болсон ‘аффект суурьтай дүрэм’ гэх зүйл бий болж буй юм. Үүнийг ажиглагчдад сөрөг сэтгэл хөдлөлийн хариу үүсгэдэг үйлдлүүдийг хориглох дүрэм хэмээн томъёолж болно.

Эллиот Туриел (Turiel, 1987) болон түүний хамтрагчдын хийсэн судалгаа Николсын онолын эмпирик үндэслэлийн цөм болдог хэмээж болно. Үнэндээ Николс Туриелийн судалгаанаас гадна түүнээс нөлөө авч хийсэн олон төстэй туршилт, судалгааг эшилсэн бий. Тэд хүмүүсээр (бага насны хүүхдүүдийг оролцуулаад) өөр өөр дүрмийн зөрчлүүдийг нэгдүгээрт эрх мэдлээс (authority) хамааралтай эсэх, хоёрдугаарт түгээмэл (соёлоос үл хамаарсан) гэж үзэж буй эсэхийг үнэлүүлжээ. Үүний цаана

дүрэм бол тодорхой соёлд буй хүмүүсийн зөвшилцөл эсвэл эрх мэдэлтэй хүмүүсийн тогтоосон зүйлс болж байдаг гэх санаа цухуйж буй бөгөөд дүрэм, сэтгэл хөдлөл хоёр ямар холбоотойг судлахад тус болж байгаа юм. Ийм судалгаануудын үр дүнд хүүхдүүд нэлээд бага наснаасаа эхлээд ёс суртахууны болон тогтсон соёлын (conventional) зөрчлүүдийг ялгадаг болох нь тогтоогджээ. Хүмүүс бусдад хор учруулах гэх мэт илүү ёс суртахууны утга бүхий зөрчлүүдийг эрх мэдэл бүхий хүмүүс (багш, эцэг, эх гэх мэт) юу гэж хэлэхээс үл хамаараад буруу бөгөөд энэ нь түгээмэл байна хэмээн үнэлсэн байна. Эсрэгээрээ хувцаслалт, хоолоо идэх соёл зэрэг бие зөв авч явахтай (etiquette) холбоотой (conventional) зөрчлийг харин эрх мэдэл бүхий хүмүүсийн хэлснээр дүгнэх хандлагатайгаас гадна түгээмэл бус буюу тодорхой соёлын онцлогоос хамааралтай хэмээн үзэж байжээ. Никослын олж харснаар хүмүүс тодорхой соёлд буй хүмүүсийн зөвшилцөл эсвэл эрх мэдэл бүхий хүмүүсийн хандлагаас үл хамааран зөвшөөрч боломгүй хэмээн үзэж буй зөрчлүүд нь хүчтэй сөрөг сэтгэл хөдлөлийн (ой гутахыг ч оруулна) хариу төрүүлдэг зүйлс ажээ (Nichols, 2004).

Хүмүүсийн үнэлгээнээс үзвэл ёс суртахууны дүрэм зөрчсөн гэж тооцогдох зүйлс нь гол төлөв бусдад хор хүргэх явдал байжээ. Нэг сонирхолтой зүйл нь, татвараас бултаг гэх мэт зарим нэг хуулийн зөрчлийг хүмүүс тогтсон соёлын зөрчилд тооцох хандлагатай байдаг бол эвгүй хоол идэх эсвэл бэлгийн амьдралтай холбоотой гэх мэт ой гутсан мэдрэмж төрүүлж болох зөрчлүүдийг ёс суртахууны төрөлд (эрх мэдэл эсвэл зөвшилцлөөс үл хамаарсан) оруулах хандлагатай байдаг аж.

Майкл Слөүт бол өнөө үед буй эрхэм чанарын ёс зүйн (virtue ethics) гурван гол хандлагын нэг болох үйл эрхлэгч төвт (agent centered) эрхэм чанарын ёс зүйн гол төлөөлөгч юм. Тэр бишрэл (admiration) төрүүлэх зан чанаруудыг (trait) эрхэм чанар гэж үздэг нь (Slote, 1995) эрхэм чанарын ёс зүйн телеологи суурьтай аристотельч хэлбэрээс татгалзаж, сентименталист арга зүйгээр эрхэм чанарыг авч үзэх оролдлогынх нь үр дүн байсан гэж болно. Хожуу үедээ, онцолбол *Ёс суртахууны сентиментализм* (2010) гэх бүтээлдээ арга зүйн хувьд асрахуйн ёс зүй (care ethics)-рүү шилжсэн байдаг. Ингэснээр асрахуйн ёс зүйн сентименталист хэлбэрийн нэг гол төлөөлөгч болсон юм (асрахуйн ёс зүй угаас сентименталист суурьтай боловч сентименталист бус хэлбэрүүд ч төрөн гарсан байдаг). Энэ өгүүлэлд түүний *Ёс суртахууны сентиментализмдаа* боловсруулсан санаануудыг нь л авч үзнэ. Тус номд Слөүт норматив болон мета ёс зүйн асуудлуудыг цогцоор нь шийдэхийг зорьсон бий. Нэгдүгээрт ёс суртахууны хэм хэмжээг хоёрдугаар эрэмбийн эмпатид тулгуурлан үндэслэх гэж оролдсон. Хоёрдугаарт, экспрессивистүүдтэй эсрэгцэн ёс суртахууны шийдэмжийг үнэн байх боломжтой гэж үзээд зогсолгүй өөрийнхөө хагас крипкеч хандлага хэмээн нэрлэсэн аргачлалаараа ёс суртахууны нэр томъёо нь натурал төрөлд (natural kind) хамаарна гэдгийг нотлохоор зорьсон бий.

Сентименталистуудын хувьд ёс суртахууны хэм хэмжээний үндэслэл болдог зүйл бол ёс суртахууны зөвшөөрөл (approbation) мөн. Хатчсон хүн Эзэн тэнгэрээс заяасан ёс суртахууны мэдрэмжийн дагуу зарим зүйлийг ёс суртахууны үүднээс зөвшөөрдөг хэмээн үзэж байхад Хьюм, Смит нар аль болох үл алагчлах хандлагын үүднээс бусдын зовлон хийгээд сайн сайхан байдалд анхаардаг хүмүүсийн зөвшөөрдөг зүйлийг ёс суртахуунтай хэмээдэг. Харин Слөүт зүгээр л бусдын мэдрэмжийг хуваалцах (аффектив, когнитив эмпатиг аль алийг нь хамруулаад) явдал нь юу ёс суртахуунтайг хэлж чадахгүй хэмээн үзсэн байна. Ингэхдээ тэр эмпатиг мэдэрдэг эмпати буюу хоёрдугаар эрэмбийн эмпатины талаар ярьсан бий.

Юуны түрүүнд эмпатиг зүгээр л бусдын мэдрэмжийг хуваалцах эсвэл бусдын оронд өөрийгөө тавих явдал хэмээн үзэх юм бол үүнд тулгуурлаж ёс суртахууны норматив

онол гаргах боломж хязгаарлагдмал. Харин хүн бусдад эмпатитайгаар санаа тавих (empathetic concern) явдал бол бусдын сайн сайханд анхаарал хандуулах байдлыг илэрхийлэх бөгөөд ёс суртахууны хэм хэмжээний суурь болох чадамжаараа хавьгүй илүү юм (үнэндээ Хьюм, Смит нарын ярьж байсан симпати бол эмпатитайгаар санаа тавих явдал байсан гэхэд буруудахгүй). Майкл Слөүтийн ярьж буй хоёрдугаар эрэмбийн эмпати бол аливаа үйл эрхлэгч бусад хүмүүст чин сэтгэлээсээ эмпатитайгаар санаа тавьж буй эсэхийг мэдрээд дулаан (warmth) эсвэл хүйтэн (chilling) мэдрэмж авах чадвар аж (Slote, 2010). Чин сэтгэлээсээ эмпатитай санаа тавьдаг хүний байдал хийгээд үйлдлийг харахад дулаан мэдрэмж төрдөг бол тийм санаа тавих чадвар хомс хүний байдал хийгээд үйлдлийг харахад хүйтэн мэдрэмж төрдөг. Үүгээр барахгүй, хоёрдугаар эрэмбийн эмпати нь аливааг гуравдагч биеэс хүлээн авдаг тул үйл эрхлэгчид (agent) өөрийнхөө өнгөрсөн үйлдлүүдийг ч хөндлөнгөөс мэдрэх боломж олгож буй юм. Ингэж өөрийн болон бусдын үйлдэл, байдлыг эмпацийн эмпатигаар мэдрэх чадвар нь үйл эрхлэгчид тодорхой үйлдлийг хийх сэдэл төрүүлж, үйлдлийг нь чиглүүлэх үүргийг ч гүйцэтгэнэ. Эцсийн дүндээ бол, Слөүтийнхөөр хоёрдугаар эрэмбийн эмпатигаар дулаан мэдрэмж авч байна гэдэг нь өөрөө ёс суртахууны зөвшөөрөл өгч буй хэрэг болдог (тэрнээс мэдрэмжээ шүүж, дүгнэх явдал биш). Үүгээрээ тэр сонгодог сентименталистуудын ёс суртахууны зөвшөөрөл гэдгийг өөрт төрсөн мэдрэмжээ ухамсраараа барьж аван үнэлэх явдал хэмээн үздэг байснаас ялгардаг.

Мета ёс зүйн хувьд Слөүт өмнөх үеийн сентименталистууд буюу Айер, Блэкбурн зэрэг мета ёс зүйн экспрессивистүүдийг эсэргүүцэж, ёс суртахууны нэр томъёонууд, шийдэмж буюу баталмал өгүүлбэрүүд нь бодитой төдийгүй натурал зүйлийн талаар өгүүлдэг гэдгийг батлахаар зорьсон бий. Энэ зорилгодоо тэр Крипкегийн натурал төрлүүдийн талаарх судалгааны үлэмж ололттой талуудыг ашиглажээ.

Юуны түрүүнд Крипке аналитик а постериори үнэн бодомж байх боломжийн тухайд ярьдаг. Аналитик а постериори үнэн бодомж бол субъект болон предикат нь хоёул чанд оноогч (rigid designator) байдаг тийм бодомж мөн (Kripke, 1980). Чанд оноогч гэдэг нь харин анхдагч баптизмаас хойш бүх бололцоот ертөнцөд нэг зүйлээ заадаг (референтээ болгодог) нэр томъёо юм. Анхдагч баптизм бол үгийг анх референттэй нь холбох явдал. Жишээ нь, тухайлсан нэг хүнд 'Ньютон' гэдэг нэр оноосон бол тус оноолтын цэгээс хойш бололцоот бүх ертөнцөд 'Ньютон' гэх нэрээр зөвхөн мөнөөх хүнийг л заана. Түүнийхээр оноосон нэрс ямагт чанд оноогч байдаг. Гэхдээ оноосон нэрээр барахгүй 'алт', 'ус', 'бар' зэрэг ерөнхий нэр томъёонууд (оноосон нэр бол нэгж нэр томъёо) ч бас чанд оноогч болж чаддаг. Гол нь тэдний байгаль дээрх мөн чанар нь олддог байх хэрэгтэй. Жишээ нь, ус бол H₂O гэх химийн бүтэцтэй бодис байна. Тийм бол анхдагч баптизмаар 'ус' гэдэг үгэнд H₂O гэдэг бодисыг л оноосон гэсэн үг. Тэгвэл үүнээс хойших бүх бололцоот ертөнцөд 'ус' гэх үг нь XYZ ч юмуу өөр ямар нэг бодисыг бус зөвхөн H₂O-г нэрлэж таарна. Угтаа H₂O гэдэг нь ч бас бүх бололцоот ертөнцөд нэг л төрөл объектыг заах учраас өөрөө чанд оноогч мөн. Ингээд 'ус бол H₂O' гэх бодомж бүх боломжит ертөнцөд үнэн буюу зайлшгүй үнэн байна гэсэн үг. Үүгээр тус бодомж аналитик гэдгийг харууллаа. Харин 'ус бол H₂O' гэдгийг хүмүүс а priori байдлаар эргэцүүлж бус эмпирикээр нээн илрүүлж мэддэг. Тийм бол энэ бодомж а постериори байж таарна.

Крипке чанд оноогчдоо хүний хариу үйлдлээс үл хамаарсан буюу анхдагч чанарт хамаатуулж болох шинжүүдийг л хамруулж үздэг. Иймд, жишээ нь, өнгө гэх хүний хариу үйлдлээс хамаарч бий болдог шинж (хоёрдогч чанарын шинж) бол натурал төрөлд хамаарч чаддаггүй. Учир нь аливаа организм мэдрэхүйн тогтолцооны онцлогоосоо хамаараад өөр өөр гэрлийн долгионыг өөр өөр өнгө болгож харах

боломжтой. Нэг ёсондоо улаан өнгө өөр өөр бололцоот ертөнцөд өөр өөр объектыг нэрлэж байх боломжтой. Тийм бол улаан өнгөний хөдөлшгүй мөн чанарыг ус бол H₂O гэдэгтэй ижлээр тогтоох аргагүй юм.

Гэхдээ Слөүт хагас-крипкеч хандлага гэдгээрээ хоёрдогч чанарын шинжүүдийг ч натурал төрөлд хамаатуулах боломжтой хэмээн үзжээ. Жишээ нь ‘улаан’ гэх үгийн референсийг бид тодорхой туршлагадаа л оноодог. Өөрөөр хэлбэл улаан өнгөний мөн чанар бол улаан гэж мэдрэгдэх байдал л юм. Ингээд үзвэл Крипкегийнхтэй яг ч ижил биш боловч улаан өнгөний тухайд түүнийхтэй тун төстэй референсийн төвшитгөл (reference-fixing) хийж болдог. Үүнийг ёс суртахуун дээрээ буулгаад үзэх юм бол ‘сайн’ гэдгийн референсийг тодорхой мэдрэмжид л хамаатуулдаг. Ёс суртахууны хувьд сайн гэдэг бол дулаан мэдрэмж төрүүлэх л явдал юм. Тэгвэл ёс суртахууны шинж заасан үгсийг ч натурал төрөлд хамаатуулах боломж бүрдэж буй юм. Ийн үзсэнээрээ Слөүт ёс суртахууны шинж заасан үгсийг бүрэн релятив утгатай эсвэл огтоос утгагүй зүйл гэх анти-реалист үзлээс зайлсхийгээд зогсохгүй ёс суртахууныг хүний хариу үйлдлээс огтоос хамааралгүй, анхдагч чанарын шинж шиг объектив утгатай гэх үзлийг ч мөн эсэргүүцэж буй юм.

Энэ өгүүллийн төгсгөл болгож Жонатан Хайдтын нийгмийн интуиционизмийн талаар авч үзье. Энэ үзлийг сентиментализмд хамаатуулах хоёр гол шалтгаан бий гэж үзэж байна. Нэгдүгээрт, интуиц гэж чухам юуг хэлж байгаа нь бүрхэг эсвэл хоёрдмол утгатай байдаг (давхар боловсруулалтын онолыг ёс зүйд хэрэглэх гэхдээ тэдний хэрэглэдэг интуиц хэмээх нэр томъёог авч хэрэглэсэн нь ёс суртахууны онол дахь сентиментүүдтэй таараад байдаг). Хоёрдугаарт, Хайдтын нийгмийн интуиционизмоороо шийдэх гэсэн гол асуудал бол Хьюм зэрэг сонгодог сентименталистууд болон рационалистуудын хоорондох ёс суртахууны шийдэмжийн үндэс нь оюун ухаан эсвэл оюун ухаанаас урьдач мэдрэмж хоёрын аль нь болох талаарх асуудал л байсан юм. Тэр 20-р зууны ёс суртахууны боловсрол, ёс суртахууны сэтгэл судлалын салбарт Пиажегээс эхлээд Колбергээр (Piaget, 1932; Kohlberg, 1969) дамжин ноёлж ирсэн рационалист уламжлалыг шууд хүлээн авахаас татгалзаж, сонгодог сентименталистуудын санаанд тулгуурласан тайлбарыг илүүд үзсэн бий.

Ерөнхийд нь авч үзвэл Хайдт нь Ниссбет (1977) тэргүүтэй шийдвэр гаргалтын онолчдын хөгжүүлсэн давхар боловсруулалтын онолоор (dual process theory) ёс суртахууны сэтгэл судлалын нэг чухал асуудлыг шийдэх гэж оролдсон бий. Давхар боловсруулалтын онолчид хүний бодох үйл явцыг дан ганц ухамсартай үйл явцаас тогтдог гэх уламжлалт хандлагыг түрж унагасан гэж болно. Энэ онолын үүднээс бодол нь хоёр тусдаа үйл явцаас тогтдог. Эхнийх нь түргэн, хүч чармайлт шаарддаггүй, автомат интуиц. Хоёр дахь нь удаан, хүч чармайлт шаарддаг, ухамсартай эргэцүүлэл. Хожим нь Канэман (2011) энэ хоёр үйл явцыг систем 1 болон систем 2 гэж томъёолсон нь олонд түгсэн юм.³ Бид шийдвэр гаргахдаа маш олон тохиолдолд интуицээ буюу систем 1-ээ дагадаг. Энгийнээр үүнийг хүнд байдаг баримжаа гэж хэлж болно. Жишээ нь, та ойд явж байгаад могой харах юм бол шийдвэр гаргахаасаа өмнө могой гэж юу вэ, үүнийг яагаад могой гэж тооцох вэ гэх мэтээр ухамсартай эргэцүүлэл хийх шаардлагагүй. Хүнд хуримтлагдсан туршлага энэ нөхцөлд юу хийх нь зөв талаарх хангалттай найдвартай (reliable) баримжаа бий болгосон байх бөгөөд тухайн хүнийг могой харсан даруйдаа өөрийгөө хамгаалах үйлдэлд хүргэдэг. Эсвэл ширээний теннис

³ Хайдтын *Сэтгэл хөдлөлийн нохой ба түүний рациональ сүүл* гэх өгүүлэлдээ Хайдт тус онолыг ашигласан ч гэлээ Канэманы систем 1 болон систем 2 гэх томъёолол гарч ирээгүй байсан. Гэсэн ч өгүүллийг уншихад илүү амар болгох үүднээс би Хайдтын үзлийг тайлбарлахдаа эдгээр томъёоллыг ашиглах болно.

тоглож буй хүн тогтлолтын үеэр тэр бүр нарийн тооцоо хийж чадахгүй учир олон тохиолдолд өдий хүртэлх туршлагаараа хэлбэржүүлсэн баримжаалалдаа л найдаж таардаг. Ийм баримжаа нь ухамсартай биш ч гэлээ хүний үйлдлийг оновчтой чиглүүлж байдаг. Эсрэгээрээ хүн хүнд математикийн бодлого бодох, ярвигтай санхүүгийн тооцоо хийх болвол систем 2-оо ашиглаж ухамсартайгаар тунгаан бодохоос аргагүй. Нэг ёсондоо энэ хоёр систем өөр өөр нөхцөлд, өөр өөрийнхөө ашиг тусыг өгч байдаг процессууд юм.

Давхар боловсруулалтын онолын линзээр сентиментализм, рационализмын маргааныг харах аваас сентименталистууд ёс суртахууны шийдэмжийг систем 1-ээс гаралтай гэж үздэг бол рационалистууд үүнийг систем 2-т хамаатуулдаг. Харин Хайдт ёс суртахууны шийдэмж эхлээд систем 1-дээр бий болж, Систем 2 нь систем 1-дээр гарсан шийдвэрийг зөвтгөх үндэслэл эрдэг хэмээн үзсэн юм (Haidt, 2001). Үүнийгээ тэр хүний ой гутам нөхцөл байдлыг дүрсэлсэн бодлын туршилтууд ашиглаад эвлэгхэн нотолчихдог. Жишээ нь:

Нэг залуу долоо хоног бүр хүнсний дэлгүүрээс бүтэн тахиа авдаг. Гэхдээ тэр тахиаг эхлээд гар хангалга хийхдээ ашиглаад, дараад нь түүгээрээ хоол хийж иддэг.

Хүмүүс энэ үйлдлийг шууд л буруу гэж толгой дотроо шийдэх хандлагатай байдаг. Хэрэв хүмүүсээс яагаад буруу болох талаар илүү нухацтай хариулт нэхвэл дийлэнхидээ гацаж таарна. Энэ нь хүмүүс тус үйлдлийг яагаад буруу болох талаар эргэцүүлж, үндэслэл хайхаас урьдаар буюу систем 2 ажиллахаас урьдаар тус үйлдлийг зөв эсвэл буруу эсэхийг шийдчихсэн байгааг харуулдаг.⁴ Рационалист загвараар бол хүн нөхцөл байдлыг систем 2-оор боловсруулсныхаа дараа л аливаа зүйл зөв эсвэл буруу болохыг шийддэг. Харин хайдтынхаар бол бид аливаа үйлдэл зөв эсвэл буруу болох талаарх шийдэмжээ систем 1-дээр түрүүлж гаргачихаад түүнийгээ яагаад оновчтой болох талаарх нэмэлт үндэслэлийг эрэхдээ (жишээ нь, хэн нэг хүн яагаад гэж асуусны дараа) л систем 2-оо нэмж ажиллуулдаг. Харин интуиц буюу систем 1 маань бидний туршлага буюу нийгэм, соёлоосоо сурсан зүйлсээр хэлбэржсэн байдаг.

Ном зүй:

Ариун Библи. (2013). Ариун Библи 2013 [Mongolian Bible version]. Mongolia Union Bible Society. <https://www.bible.com/bible/1590/ROM.2.14-15.AB2013>

Angle & M. Slote (Eds.), *Virtue ethics and Confucianism* (pp. 201–208). Routledge.

Blackburn, S. (1984). *Spreading the word: Groundings in the philosophy of language*. Clarendon Press.

Blackburn, S. (1993). *Essays in quasi-realism*. Oxford University Press.

Blackburn, S. (1998). *Ruling passions: A theory of practical reasoning*. Clarendon Press.

Chrisman, M. (2023). *What is this thing called Metaethics?* (2nd ed.). Routledge.

⁴ Философитой танил биш хүмүүст зориулсан нэмэлт тайлбар: Хайдт үүгээрээ хүмүүс бодож эргэцүүлэлгүй хөнгөн шийдвэр гаргадаг гэх буруутгасан аястай санаа дэвшүүлж байна гэж эндүүрч мэдэх юм. Гэхдээ энд тийм ая ерөөс байхгүй бөгөөд Хайдтын гол зорилго бол хүн бодит байдал дээр хэрхэн ёс суртахууны үнэлгээ өгдгийг л тодруулах юм. Түүнчлэн тэр ёс суртахууныг оюун ухаантай л наах гэдэг хандлагыг шүүмжилж буй гэдгийг мартаж болохгүй.

- Darwall, S. L. (1995). *The British moralists and the internal 'ought': 1640–1740*. Cambridge University Press.
- Driver, J. (2013). Moral sense and sentimentalism. In R. Crisp (Ed.), *The Oxford handbook of the history of ethics* (pp. 358–376). Oxford University Press.
- Geach, P. T. (1958). Imperatives and deontic logic. *The Philosophical Review*, 67(2), 305–316.
- Haidt, Jonathan. "The Emotional Dog and Its Rational Tail: A Social Intuitionist Approach to Moral Judgment." *Psychological Review*, vol. 108, no. 4, 2001, pp. 814–834. DOI: 10.1037//0033-295X.108.4.814.
- Hill, R. S. (1987). David Hume. In L. Strauss & J. Cropsey (Eds.), *History of political philosophy* (3rd ed., pp. 535–558). University of Chicago Press.
- Hume, D. (1978). *A treatise of human nature* (L. A. Selby-Bigge, Ed., 2nd ed.). Oxford University Press.
- Hutcheson, F. (1969). *An inquiry concerning moral good and evil* (D. D. Raphael, Ed.). Clarendon Press. (Original work published 1725)
- Irwin, T. (2008). *The development of ethics: Volume 2: From Suarez to Rousseau*. Oxford University Press.
- Kahneman, D. (2011). *Thinking, fast and slow*. Farrar, Straus and Giroux.
- Kohlberg, L. (1969). Stage and sequence: The cognitive developmental approach to socialization. In D. A. Goslin (Ed.), *Handbook of socialization theory and research* (pp. 347–480). Rand McNally.
- Kripke, S. A. (1980). *Naming and necessity*. Harvard University Press.
- Lau, D. C. (2003). *Mencius* (2nd ed.). Penguin Classics.
- MacIntyre, A. (1988). *Whose justice? Which rationality?* Duckworth.
- Moore, G. E. (1903). *Principia Ethica*. Cambridge: Cambridge University Press.
- Nichols, S. (2004). *Sentimental rules: On the natural foundations of moral judgment*. Oxford University Press.
- Piaget, J. (1932). *The moral judgment of the child*. Routledge & Kegan Paul.
- Putnam, H. (2002). *The collapse of the fact/value dichotomy and other essays*. Cambridge, MA: Harvard University Press.
- Rivers, E. (2005). Shaftesbury. In E. N. Zalta (Ed.), *The Stanford Encyclopedia of Philosophy* (Fall 2005 Edition). Stanford University. <https://plato.stanford.edu/entries/shaftesbury/>
- Shaftesbury, A. A.-C. (2001). *Characteristics of men, manners, opinions, times* (D. Den Uyl, Ed., 3 vols.). Liberty Fund. (Original work published 1711)
- Sidgwick, H. (1902). *Outlines of the history of ethics*. Macmillan.
- Slote, M. (1995). *From morality to virtue*. Oxford University Press.
- Slote, M. (2010). *Moral sentimentalism*. Oxford University Press.
- Smith, A. (2002). *The theory of moral sentiments* (K. Haakonssen, Ed.). Cambridge University Press.

Terjesen, A. (2013). Is empathy the one thread running through Confucianism? In S. C. Angle & M. Slote (Eds.), *Virtue ethics and Confucianism* (pp. 201–208). Routledge.

Turiel, E., Killen, M., & Helwig, C. C. (1987). Morality: Its structure, functions, and vagaries. In J. Kagan & S. Lamb (Eds.), *The emergence of morality in young children* (pp. 155–243). University of Chicago Press.

Tuveson, E. (1948). The origins of the ‘moral sense’. *Huntington Library Quarterly*, 11(3), 241–259.

The evolution of moral sentimentalism: From Shaftesbury to Slote

This paper traces moral sentimentalism's evolution from Scottish Enlightenment thinkers like Shaftesbury, Hutcheson, Hume, and Smith to contemporary philosophers, examining how this tradition positions emotions and sentiments rather than pure reason as foundational to moral judgment. Beginning with classical moral sense theory and sympathy-based approaches, the study shows how these ideas transformed into modern neo-sentimentalism through theorists like Nichols and Slote, expressivism via Ayer and Blackburn, and contemporary empirical approaches incorporating dual-process theory and Haidt's social intuitionism. The paper addresses ongoing meta-ethical debates between moral realism and anti-realism while demonstrating how sentimentalism continues to shape contemporary moral philosophy by integrating insights from care ethics and empirical psychology, ultimately bridging affective and rational elements in our understanding of virtue and moral evaluation across different philosophical periods and methodological approaches.